



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/308

Мөрөн сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Дэмбэрэл овогтой Болормаа /ФН61112968/ -нь Дархан Уул аймгийн Засаг даргын 2005 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/01 дүгээр захирамжаар газар өмчлүүлэх шийдвэр гаргуулсан байх тул Аймгийн Засаг даргын 2019 оны 12 сарын 20-ны өдрийн А/599 дүгээр захирамжийн хавсралтын 3 дугаар заалтыг тус тус хүчингүй болгосугай.

2. Мөрөн сумын Засаг даргын 2019 оны 11 сарын 06-ний өдрийн А/176 дугаар захирамжийн хавсралтын 6 дугаар заалтыг хүчин төгөлдөр хэвээр үлдээсүгэй.

3. Аймгийн Засаг даргын энэхүү шийдвэрийг оролцогчид эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН